Дорноговь аймгийн хэмжээн дэх хөдөлмөрийн чадвар алдалтаар нас, хүйсийн хамаарлыг судалсан дүн

Ц.Даваачимэг[1], Ж.Энхтуул[2], Б.Мандаасүрэн[3], Д.Сансармаа[2]*

[1,2]АШУҮИС, Дорноговь салбар АУС
[3]Дорноговь аймаг, Нийгмийн даатгалын хэлтэс
[*]Хариуцлагатай зохиогч
Цахим шуудан: davaachimeg@mnums.edu.mn, Утас: 88856405

Түлхүүр үг

Нийгмийн даатгал
Хөдөлмөрийн чадвар
Нас
Хүйс
Харьцаа

Товч утга:

Үндэслэл: Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын менежментийг сайжруулах, зорилтот бүлгийн хүн амд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хэрэгжүүлэх шаардлагатай байна. **Зорилго:** Бид энэхүү судалгааны хүрээнд Дорноговь аймгийн хэмжээн дэх хөдөлмөрийн чадвар алдалтаар нас, хүйсийн хамаарлыг судлах зорилго тавьж ажилласан. **Арга, аргачлал:** Дескриптив судалгааны аргын ретроспектив загварыг ашиглан энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ. Хугацааны цуваан дахь үзүүлэлтүүд хүйсийн хувьд ялгаатай эсэхийг Independent–sample T test ашиглан шалгасан ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон жилийн цуваанд энгийн экспоненциал тэгшитгэл ашиглан хэтийн төлөвийг тооцов. **Үр дүн:** Бидний судалгаагаар зонхилон тохиолдож буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо тасралтгүй, үзүүлэлт тус бүр өссөн дүнтэй байна. Дорноговь аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон байдал өмнөх оноос 5.5 хувиар өссөн. Хөдөлмөрийн чадвар алдалтанд хүргэж буй өвчлөлийн 79.5 хувийг мэдрэл, мэс засал гэмтэл, сэтгэц, нүд, чих хамар хоолой, дотрын өвчин эзлэж байгаа бөгөөд сүүлийн 5 жил тогтвортой буураагүй байна. Хөдөлмөрийн чадвар алдалт ба хүйсийн хамаарлыг авч үзвэл хөдөлмөрийн чадвар алдалт эрэгтэйчүүд давамгайлж байна ($p>0.001$). Насны хувьд 71.5 хувь нь ид хөдөлмөрлөх насны иргэд байна. Тухайлбал гэмтэл согогийн өвчний улмаас 30-44 насныхан, мэдрэлийн өвчний улмаас 40-49 насныхан, дотрын өвчний улмаас 50-54 насны хүмүүс хөдөлмөрийн чадвар тогтоолгосон нь харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. Сэтгэц болон зан үйлийн эмгэгийн улмаас хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн 30-34 насны эрчүүд, 40-44 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй өндөр байна. **Дүгнэлт:** Дорноговь аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон байдал өмнөх оноос 5.5 хувиар өссөн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, үзүүлэлт тус бүр тасралтгүй нэмэгдэж, хүйсийн хувьд эрэгтэйчүүд зонхилж байна ($p>0.001$). Насны хувьд 71.5 хувь нь хөдөлмөрийн насны ($p>0.003$) байна.

Үндэслэл: Нийгмийн даатгалын ерөнхий газар (НДЕГ)-ын эмнэлэг хөдөлмөр магадлах төв комиссын 2020 оны тоон тайлангаас харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хөдөлмөрийн чадвар алдалт жилээс жилд нэмэгдэж байгаа[1,4] нь хөдөлмөрийн чадвар алдалтын талаарх тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж танилцуулах, хөдөлмөрийн чадвар алдалтын зонхилох шалтгаан болж буй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, сэргээн засах, эмчлэн эрүүлжүүлэх, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын менежментийг сайжруулах, зорилтот бүлгийн хүн амд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.[2,3]

Зорилго: Дорноговь аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа

тогтоолгосон тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хүйсийн хамаарлыг тодорхойлох

Зорилт:

1. Дорноговь аймгийн хэмжээнд 2017-2021 онд бүртгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын тархалт, тохиолдлыг тодорхойлох
2. Хөдөлмөрийн чадвар алдалт ба хүйсийн хамаарлыг тодорхойлох
3. Хөдөлмөрийн чадвар алдалт ба насны хамаарлыг тодорхойлох

Арга, аргачлал: Дескриптив судалгааны аргын ретроспектив загварыг ашиглан энэхүү судалгааг хийж гүйцэтгэлээ. Монгол улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн хугацаанд бүртгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй хүн амын үзүүлэлт болон Дорноговь аймгийн хөдөлмөрийн чадвар алдалтын тайлан мэдээг ашиглан судалгааны үр дүнгийн статистикийн тоон үзүүлэлтүүдийг SPSS 20.0 программыг ашиглан боловсруулалт хийсэн. Хугацааны цуваан дахь үзүүлэлтүүд хүйсийн хувьд ялгаатай эсэхийг independent–sample T test ашиглан шалгасан ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон жилийн цуваанд энгийн экспоненциал тэгшитгэл ашиглан хэтийн төлөвийг тооцов.

Үр дүн: Дорноговь аймгийн хэмжээнд зонхилон тохиолдож буй өвчнүүдээр хөдөлмөрийн чадвар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо тасралтгүй, үзүүлэлт тус бүр өссөн дүнтэй, хүйсийн хувьд эрэгтэйчүүд давамгайлж байна (p>0.001). Түүнчлэн тус аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэн өмнөх оноос 5.5 хувиар өссөн байна (Зураг 1).



Зураг 1. Хөдөлмөрийн чадвар алдалтын тоон мэдээлэл (бодит тоогоор)

Хөдөлмөрийн чадвар алдалтанд хүргэж буй өвчлөлийн 79.5 хувийг мэдрэл, гэмтэл, сэтгэц, нүд, чих хамар хоолойн өвчин эзэлж байгаа ба нийт хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн 1656 буюу 71.5 хувь нь ид хөдөлмөрлөх 20-50 насны иргэд байна (p>0.003). Тухайлбал гэмтэл согогийн өвчний улмаас 30-34, 40-44 насныхан, мэдрэлийн өвчний улмаас 40-49 насныхан, нүдний эмгэгийн улмаас 40-44 насныхан, чих хамар хоолойн эмгэгийн улмаас 45-49 насныхан, дотрын өвчний улмаас 50-54 насны хүмүүс хөдөлмөрийн чадвар тогтоолгосон нь харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. Сэтгэц болон зан үйлийн эмгэгийн улмаас хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн 30-34 насны эрчүүд, 40-44 насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна.

Сэтгэц болон зан үйлийн эмгэгт 16 наснаас эхлээд 74 насны хүмүүс хөдөлмөрийн чадвар алдсан байгаа бөгөөд эмэгтэйчүүдийн 76.1 хувь нь, эрчүүдийн 56.3 хувь нь хөнгөнөөс эхлээд маш гүнзгий оюуны хомсдол оношоор хөдөлмөрийн чадвар алдсан байгаа нь анхаарал татахуйц үзүүлэлт байлаа. Ажилласан жилээр авч үзвэл хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн 36.6 хувь нь 1-3 жил ажилласан байна. Хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн 55 хувь нь бүрэн, 45 хувь нь хагас (хэсэгчлэн) алдсан ба ХЧА-ыг цуцлуулсан иргэдийн дийлэнх хувийг тэтгэвэр тогтоолгох, нас барсан иргэд эзэлж байгаа нь даатгуулагчдыг эмчлэн эрүүлжүүлж, хөдөлмөрийн чадварыг нь нөхөн сэргээх үйл ажиллагаа хангалтгүй байгааг харуулж байна. Энэ нь иргэдийн идэвх оролцоо муу, эрүүл мэндийн байгууллагуудад хөдөлгөөн засалч зэрэг мэргэжилтэн дутмаг, эрүүлжүүлэх ажлын төлөвлөгөө гарган үр дүнг тооцон ажилладаггүйтэй холбоотой байна.

Хэлцэмж: НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг 2008 онд соёрхон баталж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн эрхийг хамгаалах үүрэг, хариуцлага хүлээж байгаа билээ. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газар "Тогтвортой хөгжлийн зорилт 2030", Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн "Эрхийг бодит болгоё" Инчеоны стратеги 2012-2022 зэрэг хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхээр үндэсний хэмжээнд шалгуур үзүүлэлтийн хүрээг бий болгох, тооцох, үнэлэхээр ажиллаж байна. Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон НҮБ-ын гишүүн орны хувьд тус конвенцийн үзэл баримтлалд тулгуурлан үндэсний хууль тогтоомжоо боловсронгуй болгож, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэм зэргийг хүндэтгэсэн, эрхийг дээдэлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг 2016 онд Улсын Их Хурлаас батлан бусад холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр идэвхтэй ажиллаж байна.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор "Хэнийг ч орхигдуулахгүй байх уриатай Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх Ази, Номхон далайн бүсийн IV конгресс Улаанбаатар хотноо 2019 оны 07 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулсан. БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар баригдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв"-ийн барилгыг 2019 оны 01 дүгээр сард Монгол Улсын Засгийн газар хүлээн авсан. Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 125 дугаар тогтоолоор "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв"-ийг байгуулж, дүрмийг баталсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хамтран хэрэгжүүлж буй Япон улсын хамтын ажиллагааны "Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл"-ийн хүрээнд "Хөгжлийн бэрхшээл ба тэгш байдал" сургалтыг 4 дэх жилдээ зохион

байгуулж сургагч багшийг бэлтгэсэн зэрэг олон олон ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл” (DPUB, Төслийн хугацаа: 2016.05.31-2020.05.30) хэрэгжсэн байна. Түүнчлэн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, Бодлого үйл ажиллагаа: Мэдээллийн лавлах” (цагаан ном)-ыг 2018 оны 3 дугаар сард анхны мэдээллийн лавлах, 2019 онд 2 дахь дугаарыг, 2020 онд 3 дахь дугаарыг бэлтгэн гаргасан байна.

Дорноговь аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, үзүүлэлт тус бүр тасралтгүй нэмэгдэж, хүйсийн хувьд эрэгтэйчүүд зонхилж байгаа үр дүн бидний судалгаагаар гарсан бол Б.Булгантуяа,.. нарын судлаач “Дорноговь аймгийн хөдөлмөрийн чадвар алдалтын талаарх өнөөгийн байдлыг үнэлэх нь” сэдвээр нас, хүйсийг тодорхойлоход хөдөлмөрийн чадвар алдалтаар эрчүүдийн эзлэх хувь 62 хувьтай гарсан байна. Мөн 2018 онд зохион байгуулсан Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, JICA олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн төслийн үр дүнгийн тайлан, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны үр дүнгээс үзэхэд насны бүлэг ахих тусам хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо (65 ба түүнээс дээш насыг оруулахгүйгээр) нэмэгдэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаас илүү хувь нь эрэгтэйчүүд байна гэж тодорхойлсон нь эдгээр судалгааны үр дүнтэй дүйж байна.

Олон улсын түвшинд хөдөлмөрийн чадвар алдалтыг үйлдлийн олон улсын ангилалд суурилсан үнэлгээний аргачлалаар тогтоодог бол монгол улсад өвчний олон улсын ангилалаар тогтоодог байна. Иймээс 2022 оны 5 сард Үйлдлийн олон улсын ангилалд суурилсан үнэлгээний аргачлалыг турших сургалт хийж монгол улсын хэмжээнд нэвтрүүлэхээр зорин ажиллаж байна.

Харин Дэлхийн хүн амын дундаж наслалт, хүн амын чинээлэг байдал, ажил хөдөлмөр, хөдөлмөрийн орчин зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой хөдөлмөрийн чадвар алдалт харилцан адилгүй байна. Тухайлбал

Suraj Singh Senjam, Amarjeet Singh нарын “Addressing the health needs of people with disabilities in India” (PMID: 32189689) судалгаагаар Энэтхэг улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо сүүлийн хэдэн арван жилд тасралтгүй нэмэгдэж гэж тодорхойлсон нь бидний судалгааны үр дүнтэй ойролцоо байна.

Catherine A Okoro, NaTasha D Hollis нарын судлаачдын хийсэн “Prevalence of Disabilities and Health Care Access by Disability Status and Type Among Adults - United States, 2016” судалгааны үр дүнгээр 18-44 насныханы дунд танин мэдэхүйн хөгжлийн бэрхшээлтэй (10.6%) хамгийн их тархсан. Хөдөлгөөний бэрхшээл нь дунд насны (18.1%) болон ахмад настнуудын (26.9%) дунд хамгийн их тархсан, ерөнхийдөө эмэгтэйчүүдийн дунд хөгжлийн бэрхшээлийн тархалт өндөр гэж тодорхойлогдсон байхад бидний судалгаагаар залуу насныхан осол гэмтлээр, дунд болон ахмад насныхан мэдрэл болон дотрын эмгэгээр хөдөлмөрийн чадвар алдаж байгаа нь эдгээр судлаачдын үр дүнгээс ялгаатай байна.

Норвеги улсад хийгдсэн, Thomas Hugaas Moldeen* and Jan Tøssebro нарын “Disability measurements: impact on research results” судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 60 орчим хувь нь эмэгтэйчүүд байдаг ба 50 насныхан илүү өртдөг гэсэн нь бидний судалгаагааны үр дүнгээс ялгаатай байгааг бид дундаж наслалт, хөдөлмөрийн орчин, ажил хөдөлмөр эрхлэлт, цаашилбал хөдөлмөрийн чадвар алдалтын төрөл, хүндийн зэрэгтэй холбоотой гэж үзэж байна.

Дүгнэлт:

1. Дорноговь аймгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон байдал өмнөх оноос 5.5 хувиар өссөн.
2. Хөдөлмөрийн чадвар алдалт ба хүйсийн хамаарлыг авч үзвэл хөдөлмөрийн чадвар алдалт эрэгтэйчүүд давамгайлж байна ($p>0.001$).
3. Насны хувьд 71.5 хувь нь ид хөдөлмөрлөх насны иргэд байна ($p>0.003$).

Зөвлөмж:

1. Хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцлуулсан иргэдийн дийлэнх хувийг тэтгэвэр тогтоолгох, нас барсан иргэд эзэлж байгаа нь даатгуулагчдыг эмчлэн эрүүлжүүлж, хөдөлмөрийн чадварыг нь нөхөн сэргээх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.
2. Монгол хүн амын жендерийн хувьд эрчүүд цөөхөн ч хөдөлмөрийн чадвар алдалтанд эрэгтэйчүүд илүү өртөж байгаа тул тэдний эрүүл мэндийг дэмжих бодлого хэрэгжүүлэх
3. Үйлдлийн олон улсын ангилалд суурилсан үнэлгээний аргачлалаар хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож эрүүл мэндийн бүх шатны байгууллагад хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч ажлуулах, хөдөлмөрийн чадвар алдалтын дараах эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах шаардлагатай байна

Ном зүй:

1. *Янжиндулам Н. Эрүүл мэндийн судалгааны статистик дүгнэлт, 2009 [1-3], х.х 3-17*
2. *www.ndaatgal.mn (2021.05.08, 2022.01)*
3. *www.1212.mn (2021.11.15, 2022.05.28)*
4. *Дорноговь аймгийн засаг даргын тамгын газар, нийгмийн бодлогын хэлтэсийн тайлан мэдээ (2021 оны тайлан мэдээ, excel sheet хуудас-4)*
5. *Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны статистик тоо мэдээ, 2012-2021 он*
6. *Нийгмийн даатгалын сангийн статистик тоо мэдээ, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн мэдээ, 2017-2021 он*
7. *Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын тайлан, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нэгдсэн судалгаа, 2019 он*
8. *Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ (НЗУ-1), 2019 он (2022.06.06)*
9. ***Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал**: **Бодлого**, **үйл ажиллагаа**. ХНХЯ, JICA, 2020 х.х. 19-45*
10. *Altman, B.M. 2001b. Disability definitions, models, classification, schemes, and applications. In Handbook of disability studies, ed. G.L. Albrecht, K.D. Seelman and M. Bury, 97_122. London: Sage Publications Inc.*

A study of the relationship between age and sex in people with disabilities in Dornogovi province

Davaachimeg TS[1], Enkhtuul J[2], Mandaasuren B[3], Sansarmaa D[2]*

[1,2]Dornogobi Medical School, MNUMS
[3]Social Insurance Department of Dornogovi province
[*]Corresponding author
E-mail: davaachimeg@mnums.edu.mn, Tel: 88856405

Background: According to the 2020 report of the Medical and Labor Accreditation Commission of National Insurance Center, the number of people with disabilities and labor disability has been increasing year by year which shows that needs to analyze and introduce the labor disability, prevent the risk factors of labor disability, treat and rehabilitee labor disability, and improve the labor and medical accreditation management.
Aim: To analyze quantitative data on labor disability of the population with disabilities in Dornogobvi province, determine age, gender dependence.
Materials and Methods: Performed using a retrospective model of descriptive research methods.
Results: The number of people with disabilities due to the common diseases, and each indicator has increased continuously, in terms of gender, males are predominant (p>0.001). In 2020 in Dornogovi province, the percentage of labor disability and duration increased by 5.5 compared to the previous year. Seventy-nine point five percent of the total common diseases leading to labor disability are neurology, traumatology, mental, ophthalmology, and otolaryngology diseases, all cases have not decreased in the last 5 years. Considering the relationship between disability and gender, men are more likely to be disabled (p> 0.001). In terms of age 71.5 percent are of working age (p>0.003). It is noteworthy that there are many women who have been diagnosed with mental deficiency.
Conclusion: The number of people with disabilities due to the common diseases, and each indicator has increased continuously, in terms of gender, males are predominant (p>0.001). It is noteworthy that there are many women who have been diagnosed with mental deficiency. In terms of age 71.5 percent are of working age (p>0.003).

Keywords: labor disabilities, gender, age, relationship